



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.01.27 № 01/05

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын тусгай зориулалтын сангуудад санхүүгийн аудит хийх явцад 190,635,002.00 /Нэг зуун ерөн сая зургаан зуун гучин таван мянга хоёр / төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн байдлаар Байгаль хамгаалах сангийн 231,420.00 төгрөг, Мал хамгаалах сангийн 1,534,500.00 төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 185,841,082.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заасныг зөрчсөн байна.

2. Байгаль хамгаалах сангийн дансанд байршуулсан барьцаа хөрөнгөнөөс зориулалт бусаар 2008 онд 1,528,000.00 төгрөгийг Засаг даргын тамгын газрын барилгын өргөтгөлд, 2011 онд Соёлын төвд хөрөнгө худалдан авахаар 1,500,000.00 төгрөгийг тус тус зарцуулж нийт 3,028,000.00 төгрөгийг төсвийн байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.

Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолын “байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”-ын 3.10-т /Сангийн хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна 3.10.1-3.10.10/ заасан заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.2-т /омч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл

0000000009


шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн/, 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, авлагын насжилтын тайлан гаргах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх;
2. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах, шүүхэд хандаж шийдвэрлүүлэх;
3. Зориулалт бусаар зарцуулсан барьцааны хөрөнгийг сангийн дансанд буцаан төвлөрүүлэх;
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг дарга Э.Загдсүрэн, нягтлан бодогч Д.Баярцэнгэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

СУМЫН ЗАСАГ

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ



Э.ЗАГДСҮРЭН

Д.БАЯРЦЭНГЭЛ

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүнэ/